



**ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

**“Эко Яармаг-1” төслийн түр суурьшуулах  
зардлыг шинэчлэн тогтоох тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны 8 дугаар хэсгийн нутаг дэвсгэрийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн газар чөлөөлж, гэрээ байгуулсан 25 нэгж талбарын айл өрхийн түр суурьшуулах зардлыг нэг сарын 1,200,000.00 (нэг сая хоёр зуун мянган) төгрөгөөр шинэчлэн тогтоосугай.

2. Шинэчлэн тогтоосон түр суурьшуулах зардлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд олгохыг Гүйцэтгэх захирал /Э.Тамир/-д зөвшөөрсүгэй.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо /Л.Амгалан/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ШИНЭХҮҮ